Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД, АХМАД НАСТНЫ БОДЛОГЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.ЖАРГАЛЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 100% | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 3 төслийн 2023 оны хэрэгжилтийг үнэлж, тайлан дүгнэлтийг 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/530 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br><br>Дээрх төслүүдийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1-р улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайлан дүгнэлтийг Төсвийн шууд захирагч болон төслийн захирал, зохицуулагч нарт цахимаар хүргүүлсэн. Мөн төслүүдийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3-р улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмжийг ГБХНХЯ-ны ТНБД-ын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн: | 03<br><br>10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - 03/1125 дугаар албан бичгээр ХБИ-ийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл,<br>- 03/1126 дугаар албан бичгээр Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл,<br>- 03/1127 дугаар албан бичгээр Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгаалын төслийн нэгжид тус тус хүргүүлсэн. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | - | Монгол Улсын 2021-2025 оны Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан ГБХНХЯ-нд хамаарах дараах төсөл, арга хэмжээний 2024 оны хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайлан дүгнэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний дотор ЭЗХЯ-нд хүргүүлэхээр ажиллаж байна. Үүнд:<br>1. Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл,<br>2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээг сайжруулж, оролцоог нэмэгдүүлэх төсөл,<br>3. Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл.<br><br>Төслийн хэрэгжилтийн 2024 оны жилийн эцсийн тайланг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор төсөл хариуцсан нэгжүүдээс хүлээн авч хяналт-шинжилгээ үнэлгээг хийж байна.<br><br>Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт ГБХНХ-ын салбарт хамаарч байсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор” барьж байгуулах ажлыг Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 216 тогтоолоор Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хороонд шилжүүлэн хариуцуулсан байна. Үүнтэй холбоотой уг спорт цогцолборыг барьж байгуулахтай холбогдон олгосон техникийн нөхцөл, бусад баримт | 12<br><br>12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | материалыг ОНБТС-ын Үндэсний хорооны Ажлын албанд хүлээлгэн өгсөн байна. | | |
| 3. | Арга хэмжээ 1.3. Монгол улсын Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгаврын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайланг үнэлгээний цахим системд оруулж, баталгаажуулна. | Гүйцэтгэлийн хувь | - | 100% | Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулсан Монгол улсын Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилтийн тайланг холбогдох газруудаас авч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, баталгаажуулсан.<br><br>Мөн Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн №01 албан даалгаврын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, төрийн албан хаагчдын нийгмийн баталгаатай холбоотой арга хэмжээний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, цахимд оруулсан. | 01<br>12 | 100 |
| 4. | Арга хэмжээ 1.4. Монгол улсын “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх, тайлан дүгнэлтийг боловсруулж, хүргүүлнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | - | Монгол улсын Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлэх дараах заалтуудын 2024 оны тайланг бэлтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шууд удирдлагад танилцуулж, үнэлгээ хийсэн тайланг заасан хугацаанд (2024.08.01-ний дотор) ЭЗХЯ-нд цахимаар хүргүүлэн ажилласан.<br>. Үүнд:<br>6.1.1. "Цахим үндэстэн" болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх<br>6.3.5. Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх арга хэмжээний тайлан үнэлгээ хүргүүлсэн. | 07<br>08 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | Арга хэмжээ 1.5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 100% | Монгол улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Говьсүмбэр аймгуудын Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2024 оны жилийн эхний хагас жилийн биелэлтэд үнэлгээг хийж, аймгуудын нэгтгэлд хүргүүлсэн.<br>Гэрээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг 12 дугаар сарын 20-ны дотор хүлээн авч, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхээр аймгуудын ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэстэй холбогдон, мэдээлэл солилцон ажиллаж байна. | 01<br>12 | 90 |
| **Зорилт 2. "Байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэл, үр дүн, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх"** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 50% | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жил, жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг холбогдох дүгнэлт танилцуулгын хамт холбогдох удирдлагад танилцуулсан.<br>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2024 онд нийт 28 зорилт, 88 арга хэмжээ туссан байна. | 06<br>06 | 100 |
| 2. | Арга хэмжээ 2.2. Бүгд найрамдах Солонгос улс дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 50% | Бүгд найрамдах Солонгос улс дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жил, жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг холбогдох дүгнэлт танилцуулгын хамт холбогдох удирдлагад танилцуулсан.<br>БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 14 зорилт, 36 арга хэмжээ туссан байна. | 06<br>06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Арга хэмжээ 2.3. Яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 50% | ХНХЯ-ны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жил, жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг холбогдох дүгнэлт танилцуулгын хамт холбогдох удирдлагад танилцуулсан.<br><br>Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2024 онд нийт 3 зорилт, 26 арга хэмжээ туссан байна. | 06<br>06 | 100 |
| 4. | Арга хэмжээ 2.4. Яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 50% | ХНХЯ-ны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жил, жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг холбогдох дүгнэлт танилцуулгын хамт холбогдох удирдлагад танилцуулсан.<br><br>Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2024 онд нийт 3 зорилт, 22 арга хэмжээ туссан байна. | 06<br>06 | 100 |
| 5. | Арга хэмжээ 2.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 50% | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн эхний хагас жил, жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг холбогдох дүгнэлт танилцуулгын хамт холбогдох удирдлагад танилцуулсан.<br>Гүйцэтгэлийн тайланг ирүүлэх мэдэгдлийг ХБХХЕГ-ын Тамгын газарт утсаар хүргүүлсэн. Тайланг хүлээн авч, хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтоосон хугацаанд нь хийн гүйцэтгэж, үнэлгээний тайлан, танилцуулгыг ТЗУГ-т хүргүүлэн ажилласан. | 12<br>12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | Арга хэмжээ 2.6. Монголын Ахмадын холбоо ТББ-ын сайдтай байгуулсан 2024 оны гэрээний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 50% | Монголын Ахмадын холбоо ТББ-ын сайдтай байгуулсан 2024 оны гэрээний хэрэгжилтийн жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг холбогдох дүгнэлт танилцуулгын хамт холбогдох удирдлагад танилцуулсан.<br><br>Холбогпох тайлан, нэмэлт мэдээллийг хүлээн авч, хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтоосон хугацаанд нь хийн гүйцэтгэж, үнэлгээний тайлан, танилцуулгыг ТЗУГ-т хүргүүлэн ажилласан. | 12<br><br>12 | 90 |
| 7. | Арга хэмжээ 2.7. Яамны Төрийн захиргааны удирдлагын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 50% | ГБХНХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор багтаан хийж, үнэлгээний тайлан танилцуулгыг хүргүүлэн ажилласан. | 12<br><br>12 | 100 |
| 8. | Арга хэмжээ 2.8. Яамны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Гүйцэтгэлийн хувь | - | 50% | ГБХНХЯ-ны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор багтаан хийж, үнэлгээний тайлан танилцуулгыг хүргүүлэн ажилласан. | 12<br><br>12 | 100 |
| **Зорилт 3. “Байгууллагын үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт, үнэлгээ хийх”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. Харьяа байгууллага, нэгжийн үйл | Хяналт, шалгалт хийсэн эсэх | - | 1 | 1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн “Дотоод аудит хийх тухай” А/179 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт 2024 | 01<br><br>12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагаанд батлагдсан удирдамж, өргөдлийн хүрээнд дотоод хяналт, шалгалт хийнэ. | /тийм-1,<br><br>үгүй-0/ | | | оны 01-02 дугаар сард ажилласан. Дотоод аудитын ажлын төлөвлөгөө АБ2000-ын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн үйл ажиллагаа, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, архив, албан хэрэг хөтлөлт зэрэгт хяналт шалгалт хийж, холбогдох загварын дагуу дотоод аудитын тайлан боловсруулж, ажлын хэсгийн ахлагч болон нарийн бичигт цаасаар болон цахим (имэйл)-аар хүргүүлэн ажилласан.<br>2. Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн “Дотоод аудит хийх тухай” А/18 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, ХХҮЕГ-ын Төрийн захиргаа, санхүү, удирдлагын газрын хууль тогтоомжоор хэрэгжүүлэх чиг үүргийн төлөвлөлт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, албан хаагчдын Албан тушаалын тодорхойлолт боловсруулалт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, хэрэгжилт, дүгнэсэн байдал болон удирдамжид заасан бусад асуудлуудад шалгалт хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан. | | |
| 2. | Арга хэмжээ 3.2. Иргэдээс яам, харьяа агентлаг, төв, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд үнэлгээ хийнэ. | Үнэлгээ хийсэн эсэх<br><br>/тийм-1,<br><br>үгүй-0/ | - | 1 | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн чиглэлийн дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын байгууллага, албан тушаалтанд иргэдээс 2023 онд ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн чанарт хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зорилгоор ТНБД-ын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 03/232 дугаар албан бичгийг боловсруулан батлагдсан ажлын удирдамжийн хамт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж, 2023 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээллийг авч ажилласан. Мөн яамны ХЭБХЗГ, ХХБХЗГ-т 2023 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын бүртгэл, шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгтгэлээр 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. | 01<br><br>02 | 100 |

| Зорилт 4. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 4.1. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох хууль, журмын дагуу боловсруулсан байх. /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Хариуцсан албан тушаал (Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны хяналт шинжилгээ, үнэлгээ)-ын тодорхойлолтод заасан гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” болон Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан аргачлал, загварын дагуу боловсруулан ХШҮДАГ-ын даргаар хянуулж батлуулсан.<br><br>Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 37 дугаар тогтоол, ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн “Яамны бүтэц, зохион байгуулалтын нэгжийг шинэчлэн батлах тухай” А/20 дугаар тушаалаар батлагдсан бүтцийн дагуу хариуцсан албан тушаал (Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээ)-ын тодорхойлолтод заасан гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох аргачлал, загварын дагуу дахин боловсруулан ХШҮДАГ-ын даргаар хянуулж батлуулсан. | 01<br><br>11 | 100 |
| | | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг холбогдох журмын дагуу хугацаанд нь тайлагнасан байх. /тийм-1, үгүй-0/ | - | 1 | 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн болон жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” болон Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 98 дугаар тушаалын 6 дугаар | 06<br><br>12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хавсралтаар баталсан аргачлал, загварын дагуу боловсруулан тайлагнаж, хугацаанд нь үнэлгээнд хүргүүлсэн. | | |
| | | Тоо, мэдээллийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн байх. /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Албан бичиг, мэдээлэл хүргүүлсэн:<br><br>1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 03/94 дүгээр албан бичиг,<br>2. Төрийн нарийн бичгийн даргын 2024.02.28-ны А/34 дүгээр тушаал (Хэрэгжилтийг ханган ажиллах тухай)-ын төслийн боловсруулан батлуулж, төслийн нэгжүүдэд,<br>3. Яамны вэбсайтын Ил тод цэсний Бодлогын баримт бичгийн хэрэгжилт дэд цэсэнд оруулж байршуулах зорилгоор Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилтийн тайлан, үнэлгээний мэдээллийг бэлтгэж, яамны Мэдээлэл технологийн хэлтсийн холбогдох албан хаагчийн имэйлээр,<br>4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 03/1240 дугаар албан бичиг,<br>5. Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн нэгжид 2024 оны 05 дугаар сарын 09-ний “Баримт ирүүлэх тухай” 12/1374 дүгээр албан бичиг,<br>6. Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 12/1717 дугаар албан бичиг,<br>7. Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газарт 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 12/1718 дугаар албан бичиг,<br>8. Гадаадын зээл тусламжийн төслүүдэд 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн “Мэдээлэл ирүүлэх тухай” 12/425 дугаар албан бичиг,<br>9. Төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдэд 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн “Мэдээлэл ирүүлэх тухай” 03/720 дугаар албан бичиг, | 01<br><br>12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 10. ХБХХЕГ-т 2024 оны 10 дугаар сарын 22-ны “Мэдээлэл ирүүлэх тухай” 03/973 дугаар албан бичиг,<br>11. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хүргүүлэх зорилгоор 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн “Тайлан хүргүүлэх тухай” 03/1124 дүгээр албан бичиг,<br>12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн нэгжид 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 03/1125 дугаар албан бичиг,<br>13. Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн нэгжид 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 03/1126 дугаар албан бичиг,<br>14. Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төслийн нэгжид 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 03/1127 дугаар албан бичиг,<br>15. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 12/1345 дугаар албан бичиг,<br>16. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Ёс зүйн асуудал, судлан шийдвэрлэх тухай” 12/1346 дугаар албан бичиг,<br>17. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 03/1401 дүгээр албан бичгийг тус тус хүргүүлсэн. | | |
| 2. | Арга хэмжээ 4.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд | Архивын нэгжийг бүрдүүлж хүлээлгэн өгсөн байх. /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн 2023 оны хэрэгжилтэд үнэлгээ хийсэн тайлан, танилцуулга зөвлөмжийг архивын нэгж болгон хүлээлгэн өгсөн. | 04<br>06 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ. | Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг хүргүүлсэн эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Иргэд байгууллагаас ирүүлсэн дараах өргөдлүүдийг судалж, шийдвэрлэн хуулийн хугацаанд хариуг хүргүүлэн ажиллалаа. Үүнд:<br><br>1. ХНХ-ын сайдад Иргэн Ш-ээс ирүүлсэн өргөдлийн хариуг 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 12/16 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Өргөдөлтэй холбоотой асуудлаар ХХҮЕГ-т 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 03/94 дүгээр албан бичгийг хүргүүлсэн.<br>2. ХНХ-ын сайдад Иргэн Я-аас ирүүлсэн өргөдлийг судалж, шийдвэрлүүлэхээр 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 12/51 дугаар албан бичгийг ХХҮЕГ-т хүргүүлсэн.<br>3. ХНХ-ын сайдад болон ХНХЯ-ны ТНБД-д ахмад настан Б-ээс удаа дараа (3 удаа) ирүүлсэн өргөдлийг судалж, холбогдох хариуг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 03/106 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Уг өргөдлийг шийдвэрлэх явцад илэрсэн зөрчлийг арилгах, дахин үүсэхээс сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг чиглэл болгож 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 03/1240 дүгээр албан бичгийг ХХҮЕГ-т хүргүүлсэн.<br>4. ХНХЯ-нд Хүүхдийн тусламжийн 108 утасны ажилтан Э-ээс ирүүлсэн өргөдлийг судалж, холбогдох хариуг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 12/161 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Өргөдөлтэй холбоотой асуудлаар ХГБХХЕГ-т 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 12/1718 дугаар, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд 12/1717 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн.<br>5. ГБХНХ-ын сайдад Иргэн Н-ээс ирүүлсэн өргөдлийн судалж, хариуг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр холбогдох дугаарын утсаар ярьж хүргүүлсэн. Уг өргөдөлтэй холбоотой Авлигатай тэмцэх газрын 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн “Гомдол мэдээлэл | 01<br><br>12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шилжүүлэх тухай" 05/17350 дугаар албан бичгийг хаасан.<br>6. ГБХНХ-ын сайдад Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн ажилтан А-аас ирүүлсэн өргөдлийг судлан ажиллаж, хариуг 2024 оны 11 дүгээр сарын 21-ний 12/98 дугаар албан бичгээр хүргүүлэв.<br>7. ГБХНХ-ын сайдад Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн ажилтан С-ээс ирүүлсэн өргөдлийг судлан ажиллаж, хариуг 2024 оны 11 дүгээр сарын 21-ний 12/99 дүгээр албан бичгээр хүргүүлэв.<br>8. ХНХ-ын сайдад Иргэн Б-ээс ирүүлсэн өргөдлийг судалж, шийдвэрлэн хариуг 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 12/101 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. | | |
| | | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь мэдүүлсэн байх. /тийм-1, үгүй-0/ | - | 1 | 2023 оны жилийн эцсийн байдлаарх Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь (2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр) Авлигатай тэмцэх газрын холбогдох цахим системд оруулан мэдүүлж, баталгаажуулсан.<br><br>Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 37 дугаар тогтоол, ГБХНХЯ-ны ТНБД-ын 2024 оны А/20 дугаар тушаалаар батлагдсан бүтцийн хүрээнд АТГ-ын ХАСХОМ-ын цахим системд холбогдох шинэчлэл (яамны нэр өөрчлөгдсөнтэй холбоотой)-ийг 2024 оны 3-р улирaлд хийж баталгаажуулсан. | 01<br><br>10 | 100 |
| 3. | Арга хэмжээ 4.3. Салбарын хууль тогтоомжийн болон статистик тоо мэдээллийн сан үүсгэж, мэдээллийг | Салбарын хууль журмын сан бүрдүүлсэн байх. /тийм-1, Үгүй-0/ | - | 1 | 2024 оны 1,2 дугаар улиралд хариуцсан чиг үүргийн дагуу Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой хууль, дүрэм, журмын санг бүрдүүлж ажилласан.<br><br>2024 оны 3 дугаар улирлаас эхлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, Ахмад настны тухай хууль, дүрэм, журмын судалгааг хийж, мэдээллийн санг үүсгэн ажиллаж байна. | 01<br><br>12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тухай бүрт шинэчлэн баяжуулна. | | | | Мөн төрийн байгууллагад нийтлэг мөрдөгдөх хууль, тэдгээрийн үүргийн заалтын судалгааг хийж, жагсаалт гаргасан. | | |
| | | Статистик мэдээллийн сан бүрдүүлсэн байх. /тийм-1, үгүй-0/ | - | 1 | 2024 оны 08 дугаар сараас Хөгжлийн бэрхшээлийн салбарын болон Ахмад настны талаарх статистик тоо мэдээллийг цуглуулж, сан бүрдүүлэн ажиллаж байна. | 01<br>12 | 90 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.<br>ХНХ-ын салбарт гадаадын зээл тусламжаар 2020-2023 онд хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилт, үр дүнд хяналт, явцад дүн шинжилгээ хийх шалгалтын тушаал, ажлын удирдамж боловсруулан батлуулах | Тушаал удирдамж батлуулсан эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | ХНХ-ын салбарт гадаадын зээл тусламжаар 2020-2023 онд хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилт, үр дүнд хяналт, явцад дүн шинжилгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын удирдамжийг батлах ТНБД-ын тушаалын төслийг боловсруулан 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/95 дугаар тушаалаар батлуулсан. | 05<br>06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.<br><br>ХНХ-ын салбарт гадаадын зээл тусламжаар 2020-2023 онд хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилт, үр дүнд хяналт, явцад дүн шинжилгээ хийх | ХНХЯ-ны ТНБД-ын 2024 оны А/95 тушаалаар баталсан хяналт шалгалт хийх ажлын удирдамжийн дагуу Хяналт, шалгалт хийсэн эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | ХНХЯ-ны ТНБД-ын 2024 оны А/95 тушаалаар ХНХ-ын салбарт гадаадын зээл тусламжаар 2020-2023 онд хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилт, үр дүнд хяналт, явцад дүн шинжилгээ хийх ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хэсэгт ажиллаж, Дэлхийн банкны хөнгөлөлтэй зээлээр хэрэгжсэн “Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих төсөл”, одоо хэрэгжиж буй “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийн 2020-2023 оны хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, төслийн нэгж, төслийн захиралд танилцуулсан. | 05<br><br>06 | 100 |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.<br>Холбогдох газраас ирүүлсэн журмын төсөлд санал өгөх | Журмын төсөлд санал өгсөн эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэх, санхүүжилт олгох журмын төсөлд холбогдох саналыг боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Хөдөлмөр, эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлсэн. | 04<br><br>04 | 100 |
| 4. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.<br>Холбогдох байгууллагуудтай хийх уулзалт, хэлэлцүүлэгт оролцох | Уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Газрын даргын өгсөн үүрэг чиглэлийн дагуу гадны байгууллага дээр зохион байгуулагдсан дараах уулзалт, хэлэлцүүлэгт оролцож, санал солилцон ажиллалаа. Үүнд:<br><br>1. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан Мягмар гарагийн дараах Өглөөний уулзалтад оролцсон. Үүнд:<br>- 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 8.00 цагт “Бодлогын өртөг тооцох олон улсын туршлага ба кейсын судалгаа”<br>- 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 8.00 цагт “Уламжлалт ба үр дүнд суурилсан төлөвлөлтийн арга зүйн хүрээнд ялгаатай боловсруулагдсан баримт бичигт үнэлгээ, мониторинг хийх асуудал шийдэл”сэдэвт уулзалтад оролцсон. | 06<br><br>12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2. ГБХНХЯ-ны байранд 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулагдсан “International Classification Functional (ICF) Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал” талуудын уулзалт хэлэлцүүлэгт оролцсон.<br>3. Сангийн яамны 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн “Хэлэлцүүлэг зохион байгуулах тухай” 09/9332 дугаар албан бичгийн дагуу 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Сангийн яаманд зохион байгуулагдсан АХБ-ны “Төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээ болон үр нөлөөг тооцох арга аргачлал, түүний гарын авлагыг танилцуулах, санал зөвлөмж авах хэлэлцүүлэгт оролцсон.<br>4. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Уулзалтад оролцох тухай” 01/999 дүгээр албан бичгийн дагуу ЗГХХГ-ын байранд зохион байгуулагдсан Салбарын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүдийг шинэчлэн боловсруулахтай холбоотой мэдээлэл өгөх, санал солилцох уулзалтад ХШҮДАГ-ын дарга, Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, албан хаагчийн хамт оролцсон. | | |
| 5. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд олон улсын сайн туршлага нэвтрүүлэх төслийн ажлын даалгавар боловсруулах | Ажлын даалгавар боловсруулсан эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Газрын даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг олон улсын ололт. сайн туршлагаар хөгжүүлэх төслийн зөвлөхүүд (3)-ийн ажлын даалгаврыг 2024 оны 09 дүгээр сард боловсруулан танилцуулсан. | 09<br>09 | 100 |
| 6. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. | Ажлын хэсгийн гишүүний үүргийг | - | 1 | ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар | 09 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Салбарын тогтолцооны загвар боловсруулах, эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийх ажлын хэсэгт ажиллах | гүйцэтгэж ажилласан эсэх /тийм-1, үгүй-0/ | | | байгуулагдсан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын тогтолцооны загвар боловсруулах, эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийх ажлын хэсэгт орж Эрх зүйн актад системийн шинжилгээ хийх аргачлалын дагуу, хууль эрх зүйн актын системийн хэв шинжүүдийн бүрдлийн түвшинг шинжилж, үнэлэхэд багаар ажилласан.<br>- 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр<br>- 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан ажлын хэсгийн хуралд оролцсон. | 12 | |
| 7. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. СЗСҮТ-ийн Протез ортопедийн үйлдвэрийн 2014 онд худалдан авснаас хойш ашиглаагүй тоног төхөөрөмжийн мэдээллийг тодруулах | Мэдээллийг нягтлан шалгаж, холбогдох дүгнэлтийг гаргаж удирдлагыг мэдээллээр хангасан эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны удирдлагуудыг бодит мэдээллээр хангах, нөхцөл байдал газар дээрээ ямар байгааг тодруулах зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Сэргээн засалт сургалт, үйлдвэрлэлийн төвд 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр очиж ажилласан. Газар дээрх бодит байдлын зураг мэдээллийг авч, санхүүгийн баримт материалыг үзэж, асуудал хариуцан албан тушаалтнуудтай уулзаж, шалгалтыг ажлын холбогдох дүгнэлт мэдээлэл боловсруулж, удирдлагад өгсөн. | 10<br>10 | 100 |
| 8. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8. Үзлэг шалгалт хийх асрамж, халамж, сэргээн засах байгууллагуудад ажиллах | Холбогдох байгуулагад очиж ажилласан эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн “Үзлэг шалгалт зохион байгуулах тухай” А/133 дугаар тушаалын дагуу 2024 оны 12 дугаар сард Ахмад настны үндэсний төв, “Өнөр бүл” хүүхдийн асрамжийн төвд тус тус ажлын хэсгийн гишүүдийн хамт ажиллаж, холбогдох дүгнэлт мэдээллийг боловсруулж байна. | 12<br>12 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр гадаад, дотоодын 1-ээс доошгүй сургалтанд хамрагдана. | Суралцсан сэдэв, цаг | - | 1-ээс доошгүй | Удирдлагын Академиас 2024 оны 10 дугаар сарын 07,08,09,21,22-ны өдрүүдэд зохион байгуулсан “Шалгуур үзүүлэлт түүнийг хэмжих аргачлал боловсруулах нь” сэдэвт 50 цагийн сургалтад бүрэн хамрагдаж төгссөн. Үнэмлэхний дугаар №24/1513 | 10<br>10 | 100 |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Удирдлагын Академи, Төрийн албаны зөвлөл, бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдана. | Суралцсан сэдэв, цаг | - | 2-оос доошгүй | - 2024 оны 03 дугаар сарын 08-ны өдөр ОБЕГ-аас зохион байгуулсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тохиолдсон үед авах арга хэмжээ” сургалтад хамрагдсан.<br>- 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр ХНХСҮСИ-ээс зохион байгуулсан “Цалин хөлсний бүтцийн судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн Барометрийн судалгаа, үр дүнгийн танилцуулга”-т хамрагдсан.<br>- ЗГХЭГ-аас 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан АНУ-ын Кембрижийн их сургуулийн багш, олимпийн тамирчин Кет Бишопын сургалтад хамрагдсан.<br>- 2024 оны 05 дугаар 16-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 7:4:10 цахим сургалтад хамрагдсан. Сургалтаар:<br>1. УИХ-ын дарга Г.Занданшатар “Төрийн албаны шинэчлэл ба цэгцрэх хөдөлгөөн”, petition.parliament.mn – Нийтийн өргөдөл гомдлын систем | 01<br>12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2. ХНХ-ын сайд Х.Булгантуяа "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа" сэдвээр мэдээлэл өгсөн.<br>- 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр ГБХНХЯ-ны Цахимжилт, их өгөгдлийн бодлогын газраас зохион байгуулсан "Цахимаар баримт бичиг боловсруулж, илгээх нь" сургалт мэдээлэлд хамрагдсан. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ( *Албан тушаал* ) О.ЖАРГАЛ / ......О.Ж...... / ( *Нэр, гарын үсэг* ) 2024.12.05 ( *Огноо* )